



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН САНАЛ, ТӨСӨЛ

Сэдэв: Гүйцэтгэх эрх мэдлийн хариуцлагыг
нэмэгдүүлж, тогтвортой байдлыг хангах

ТӨРИЙН ОРДОН
2019 он



1.УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНЭЭР СОНГОГДСОН ХҮНИЙГ ЕРӨНХИЙ САЙДААР АЖИЛЛУУЛАХ ШААРДЛАГА БИЙ БОЛГОНО

Үндсэн хуулийн заалт:

39.1.Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ.

Төслийн заалт:

39.1.Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ.

Ерөнхий сайд Улсын Их Хурлын гишүүн байх бөгөөд Засгийн газрын бусад гишүүд Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч үл болно.



2.ЕРӨНХИЙ САЙДААС БУСАД ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДИЙГ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНЭЭР ДАВХАР АЖИЛЛАХЫГ БҮРЭН ХОРИГЛОНО

Үндсэн хуулийн заалт:

39.1.Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ.

Төслийн заалт:

39.1.Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. Ерөнхий сайд Улсын Их Хурлын гишүүн байх бөгөөд Засгийн газрын бусад гишүүд Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч үл болно.



3.3АСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ “ХАРГАЛЗАН ҮЗЭХ” ШАЛГУУР БИЙ БОЛГОНО



Төслийн заалт:

39.4.Засгийн газар Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал **БОЛОН** тогтвортой хөгжлийн бодлогод нийцсэн үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулж бүрэн эрхийнхээ хугацаанд хэрэгжүүлнэ.



4.ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ БАТЛАХААС ӨМНӨ “ХЯНАН ҮЗЭЖ” ЗӨВЛӨМЖ, ДҮГНЭЛТ ГАРГАДАГ ШАТ БИЙ БОЛГОНО



Төслийн заалт:

39.5.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцэж буй эсэхийг **Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөл** хэлэлцэн шийдвэрлэнэ.

39.6.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр Монгол Улсын тогтвортой хөгжлийн бодлогод нийцэж буй эсэхэд **хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан, хараат бус байгууллага** хяналт тавьж, дүгнэлтээ Улсын Их Хурлаар хэлэлцүүлнэ.



5.ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН ХАРААТ БУС БАЙГУУЛЛАГА БАЙГУУЛНА



Төслийн заалт:

39.7.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан, бодлогын тогтвортой байдалд хараат бусаар хяналт тавих байгууллагын чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.



6.ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ БОЛОН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО БАТЛАХАД БАРИМТЛАХ ЖУРМЫГ ТОГТООНО



Төслийн заалт:

39.8.Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон тогтвортой хөгжлийн бодлогыг Улсын Их Хурал батлах бөгөөд Ерөнхийлөгч, Засгийн газар, аймаг, хот, нийслэлийн Төлөөлөгчдийн Хурлаас санал авах, хэлэлцэх, батлах журмыг хуулиар тогтооно.



7.ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦААГ СУНГАНА

Үндсэн хуулийн заалт:

40.1.Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа **дөрвөн** жил байна.

Төслийн заалт:

40.1.Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа **таван** жил байна.



8. ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН ЗАРИМ ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛЖ, ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫГ 10 ЖИЛИЙН ХУГАЦААГААР ТОМИЛНО



Төслийн заалт:

46.4. Төрийн жинхэнэ албан хаагч яамны Төрийн нарийн бичгийн дарга хүртэл дэвшин ажиллах эрхтэй бөгөөд шатлан дэвших, чадахуйн зарчимд үндэслэсэн сонгон шалгаруулалтын болзол хангасан Монгол Улсын иргэн Төрийн нарийн бичгийн даргад чөлөөтэй өрсөлдөнө.

Төрийн нарийн бичгийн даргыг арван жилийн хугацаагаар томилно.

Төрийн нарийн бичгийн даргыг хуульд заасан үндэслэлээр чөлөөлж, огцруулна.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТАМГЫН ГАЗАР

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА